



СҮХБААТАР АЙМГИЙН ҮНДЭСНИЙ
ЭВСЭЛ НАМ-Д

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

додж. 07. 29 № 395

танай _____ -ны № _____ -т

Хандивын тайлангийн дүгнэлт

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Сүхбаатар аймгийн Үндэсний эвсэл намын хороонос ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Төрийн Аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Сүхбаатар аймгийн Үндэсний эвсэл намын хороо нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайд 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлангийн маягт, заавар”-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Нам, эвслээс дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл


Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар нь Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Сүхбаатар аймгийн Үндэсний эвсэл намын хороонд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Төрийн

Аудитын стандарт MNS 6817:2020, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/49 тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5, 55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

Дүгнэлт

Сүхбаатар аймгийн Үндэсний эвсэл намын хороо нь ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА